



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/3/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.dornogovi.audit.mn">www.dornogovi.audit.mn</a> Дорноговь аймаг 2020 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Аудитор: У.Оюунтүлхүүр Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	5
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө .....	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	
2.8.3 Авлага.....	7
2.8.4 Урьдчилгаа .....	
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	
2.8.6 Бараа материал .....	8
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	8
2.8.8 Өр төлбөр .....	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	19
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	23
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	24
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	28
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	30

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a>	<p>ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.АЛДАРБАЯР ТАНАА</p>
<u>2020.03.25 № 1-6/364</u>	
танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Замын-Үүд сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Замын-Үүд сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Замын-Үүд сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
<b>010020040</b>	

2020.03.25 №1-6/364

### Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Засаг дарга Н.Алдарбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 12-аас 2020 оны 03 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/218 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 21,015. 0 сая төгрөгийн 1 хувь буюу 210.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

#### **2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 14 төсвийн байгууллага, 3 сан, 17 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 13 байгууллага аудитын санал дүгнэлт, бусад 4 байгууллага, сан түүвэр аудитад хамрагдсан байна.

Аудитын санал дүгнэлтээр 11 байгууллага “зөрчилгүй”, 1-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг “Хязгаарлалттай” дүгнэлттэй гарсан байна.

Замын-Үүд сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 119.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.6 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 8.3 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20.4 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 87.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг хүргүүллээ.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- СХСангийн хуримтлагдсан ашиг дансыг 38.1 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн байсныг залруулав.
- Засгийн газрын оруулсан капитал дансны 4136.5 сая төгрөгийн өмч /ТӨҮГ/ дансанд нэгтгэснийг залруулсан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланг гаргахдаа дараах алдаа гарсныг залруулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд нэмэлт дансны төвлөрүүлэг 56.3 сая төгрөгийн устгах бичилт хийгээгүй байсныг залруулсан
- Үр дүнгийн тайланд 2-р сургуульд ЗД-ын нөөц сангаас олгосон 0.3 сая төгрөг, улсын төсөвт буцаан төвлөрүүлэх 64.5 сая төгрөг, ОНХО-оос байгууллагуудад хуваарилсан 2,754.8 сая төгрөг нийт 2819.7 сая төгрөгийн устгах бичилтийг хийгээгүй байсныг залруулсан
- Мөнгөн гүйлгээний тайланд байгууллагуудын үндсэн дансны үлдэгдэл төвлөрүүлсэн 121.6 сая төгрөг, 2-р сургуульд ЗД-ын нөөц сангаас олгосон 0.3 сая төгрөг, ОНХО-оос хуваарилсан санхүүжилт 2,754.8 сая төгрөг нийт 2876.8 сая төгрөгийн устгах бичилт хийгээгүйг залруулсан

#### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 1,897.3 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- СХСангийн тайланд хуулгаарх орлого зарлагын бүртгэл зээлийн үлдэгдэл тооцооллыг санхүүгийн байдлын тайланд 773.7 сая төгрөгөөр зөрүүтэй, Үр дүнгийн тайланд 280.2 сая төгрөгийн орлогыг зөрүүтэй бүртгэснийг залруулсан.
- ОНХСангийн тайланд 4.4 сая төгрөгийн ажлын санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн байх бөгөөд ажлын гүйцэтгэл 70% тай байх тул 3.1 сая төгрөгөөр дуусаагүй барилга, 1.3 сая төгрөгөөр авлага үүсгэж тайланг залруулсан. Үр дүнгийн тайланд зардлыг 9.2 сая төгрөгийн зардал илүү бүртгэснийг залруулсан
- Ерөнхий боловсролын 3-р сургуульд нийт 7 алдаанд 262.1 сая төгрөгийн залруулга хийсэн
- ЗДТГ-ын тайланд 423.2 сая төгрөгийн 4 алдааг залруулсан
- ИТХ-ын тайланд 16.3 сая төгрөгийн 2 алдааг залруулсан.
- Ерөнхий боловсролын 2-р сургуулийн санхүүгийн тайланд 78.7 сая төгрөгийн 4 алдааг залруулсан
- Ерөнхий боловсролын 1-р сургуулийн санхүүгийн тайланд 10.9 сая төгрөгийн 1 алдааг залруулсан
- Захирагчийн ажлын албаны тайланд 37.6 сая төгрөгийн 1 алдааг залруулсан.

## 2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 300.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 162.9 сая төгрөг болж 137.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	101.5	245.2	143.6	99.4
Банканд байгаа бэлэн мөнгө	3.1	1.5	- 1.6	0.6
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>104.6</b>	<b>246.7</b>	<b>142.1</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 246.7 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 245.2 сая төгрөг арилжааны банкны дансанд, 1.5 сая төгрөг байршиж байна.

### 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1077.4 сая, эцсийн үлдэгдэл 918.2 сая төгрөг болж, 159.2 сая төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	29.3	4.4	-24.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.2	0	-0.2
Татаас, санхүүжилтийн авлага	0.2	0	-0.2
Зээлийн хүүгийн авлага	12.2	45.0	32.8
Бусад авлага	107.0	15.3	91.7
Зээлийн авлага	928.4	853.4	75.0
<b>Дүн</b>	<b>1077.4</b>	<b>918.2</b>	<b>159.2</b>

*Эх сурвалж: Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

- Авлагын үлдэгдэлд: СХСангийн зээл, зээлийн хүүгийн авлага 97.8 хувийг эзэлж байна. 2011 оноос хойш шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй байгаа 51 иргэний 610.9 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Урьд онд дараах байгууллагууд жилийн эцэст авлагатай гарсан. Үүнд: 2-р цэцэрлэг 0.1 сая төгрөг, 4-р цэцэрлэг 3.3 сая төгрөг, 5-р цэцэрлэг 0.2 сая төгрөгийн авлагатай гарсан.

### 2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 376.25 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 420.78 сая төгрөг болж, 44.53 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	106.9	113.0	6.2
Эм боох материал	0.9	15.9	15.0
Бэлэн бүтээгдэхүүн		41.9	41.9
Бичиг хэргийн материал		47.3	
Аж ахуйн материал	31.8	500.9	15.5
Сэлбэг хэрэгсэл	492.7	0.4	8.1
Түлш, шатах тослох материал	0.3	1.6	0.2
Барилгын засварын материал	3.0	2.9	-1.4
Хүнсний материал	2.3	47.4	0.5
Бусад хангамжийн материал	32.4	473.8	14.9
Мал амьтад	51.9	1.1	421.8
	1.2		
<b>Дүн</b>	<b>723.6</b>	<b>1,246.4</b>	<b>522.8</b>

Эх сурвалж: Замын-Үүд сумын сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд тусгай зориулалтын материал 15.1 сая төгрөг, эм боох материал 28,1 сая төгрөг, бичиг хэргийн материал 66,5 сая төгрөг, аж ахуйн материал 129,4 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 7,8 сая төгрөг, түлш шатах тослох материал 38,4 сая төгрөг, хүнсний материал 425,2 сая төгрөг, бусад хангамжийн материал 77,7 сая төгрөг нийт 797,9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан байна. Үүнээс цэцэрлэг, сургуулийн хүүдийн хоолны материал 47,4 сая төгрөг, эмнэлгийн 15.9 сая төгрөгийн эм боох материалын үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- 1-р цэцэрлэг
  - 2019 оны сүүлийн хагас жилийн тооллого хийхээр цэцэрлэгийн эрхлэгч 2019-12-20-ны өдөр А/32 тоот тушаал гарган тооллого хийгдсэн байна. Гэвч тооллогын бүртгэл /НХмаягт БМ-8/г нягтлан бодох бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгаагүй улмаас 24186.5 сая төгрөгийн бараа материалд тооллого хийгээгүй.

### 2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6700.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6877.4 сая төгрөг болж, 176.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>17,680.57</b>	<b>21,410.18</b>	<b>3,729.61</b>
Барилга, байгууламж, орон сууц	15,209.43	18,714.02	3,504.59
Авто-тээврийн хэрэгсэл	159.68	179.11	19.42
Машин тоног төхөөрөмж(компьютер)	639.52	726.69	87.17

Тавилга, аж ахуйн эд хогшил	544.57	720.38	175.81
Зам, гүүрийн байгууламж	801.06	732.14	-68.92
Бусад үндсэн хөрөнгө	299.50	271.13	-28.37
Дуусаагүй барилга, байгууламж	0.32	3.06	2.74
Ном	26.49	63.65	37.17
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>933.53</b>	<b>986.90</b>	53.36
Програм хангамж	2.50	3.08	0.58
Бусад биет бус хөрөнгө	931.03	983.81	52.78
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>18,614.10</b>	<b>22,397.08</b>	<b>3,782.97</b>

Эх сурвалж: Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 22397.1 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 53.0 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 2940.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 53.0 сая, акталсан 275.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд Орон нутгийн хөгжлийн сангийн 1 ажлын 70 хувийн гүйцэтгэлийн 3.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

- 1-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг, 6-р цэцэрлэг ҮХ-н хөдөлгөөний өөрчлөлтийг бараа материалын тайлан /НХМаягт БМ-9 / маягтаар үнийн дүнгээр тайлагнасан байна.
- 1,2-р сургууль Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглаж байна.

#### 2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2.7 сая, эцсийн үлдэгдэл 59.2 сая төгрөг болж 56.5 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	2.7	2.9	0.2	
Ажилчидтай холбогдсон өглөг	0.2	1.2	1.0	
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.08	0.003	-0.07	
Байгууллагад төлөх өглөг	1.7	1.2	-0.5	
Хувь хүмүүст төлөх өглөг	0.6	0.5	0.1	
<b>Нийт дүн</b>	<b>2.7</b>	<b>2.9</b>	<b>0.2</b>	

Эх сурвалж: Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Ажилчидтай холбогдсон өглөг 1.2 сая төгрөг, байгууллагад өгөх өглөг 1.2 сая төгрөг, хувь хүнд өгөх өглөг 0.5 сая төгрөг байна.

**Аудитын илрүүлэлт:**

- 2-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг, 6-р цэцэрлэг жилийн эцсийн тайлангаар өглөгтэй гарсан.

**2.8.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 21,084.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 25372.5 сая төгрөг болж, 4288.6 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6754.4	6,807.5	53.0	26.8
Хуримтлагдсан үр дүн	9,633.3	13,868.9	4,235.7	54.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,696.2	4,696.1	0	18.5
<b>Дүн</b>	<b>21,083.9</b>	<b>25,372.5</b>	<b>4,288.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

/ 2019 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 12/02 дугаар тогтоолд/ зааснаар Замын-Үүд сумын тайлант онд 6691.8 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 7102.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 106.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 7. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	1885.5	1871.8	-13.7	99.3
Хөрөнгө борлуулсны орлогын татвар	120.0	50.6	-69.4	42.2
Бусад татвар	55.8	73.7	17.9	132.2
хадгаламжийн хүүгийн орлого	453.6	292.1	-161.5	64.4
Бууны албан татвар	2.5	2.8	0.3	112.06
Улсын тэмдэгтийн хураамж	1650.0	2174.2	524.2	131.7

Хог хаягдлын төлбөр	90.3	62.1	-28.1	68.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10.4	9.0	1.4	86.5
Хүү торгуулийн орлого	1840.0	2014.5	174.5	109.5
Нэр зааж ангилагдаагүй орлого	581.7	551.6	-30.2	94.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2.0			
<b>Нийт дүн</b>	<b>6691.8</b>	<b>7102.2</b>	<b>410.4</b>	<b>106.1</b>

Бусад татварын орлого, улсын тэмдэгтийн хураамжийн орлого, хүү торгуулийн орлого 845,6 сая төгрөгөөр давсан нь Гадаад иргэдийн торгууль болон визний хураамжийн орлого их байсантай холбоотой. Үйл ажиллагааны орлого, хөрөнгө борлуулсны орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хог хаягдлын орлого, нэр зааж ангилагдаагүй орлого 302.9 сая төгрөгөөр тасарсан нь арилжааны 2 банк хадгаламжийн хүүгийн орлогыг Дорноговь аймаг дах төв салбарт шилжүүлсэн мөн хилээр гарах чиглэлийн иргэдийн хөдөлгөөнөөс шалтгаалсан байна.

Баталсан төлөвлөгөөгөөр Татварын болон татварын бус орлого 6,691.8 сая төгрөг төвлөрүүлж орон нутгийн төсвийн байгууллагын санхүүжилт 2,758.5 сая төгрөг, аймагт төвлөрүүлэх орлого 3,933.3 сая төгрөгийг шилжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр татварын болон татварын бус орлого 7,102.5 сая буюу 108.06 хувиар биелж төсвийн байгууллагын санхүүжилтийг 2,754.5 сая төгрөгөөр олгосон. Аймагт төвлөрүүлэх орлогыг 3,933.3 сая төгрөгөөр 100 хувь төвлөрүүлсэн байна. 2018 оны санхүүгийн аудитаар аймагт төвлөрүүлэх 28.9 сая төгрөгийн актын төлбөр төлсөн, давсан орлого 385.4 сая төгрөгийг аймагт төвлөрүүлсэн.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 2,758.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,723.0 сая төгрөгийг урсгал зардалд, 1,035.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,756.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс, 2,754,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож төсөвт байгууллагын өөрийн орлогын 2.0 сая төгрөг, төсвөөс 2.0 сая төгрөгийг дутуу олгосон байна.

Гүйцэтгэлээр тусгай шилжүүлгийн байгууллагуудад үндсэн санхүүжилт 6,382.7 сая төгрөгөөс 79.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, Орон нутгийн байгууллагын үндсэн болон тогтмол зардлын санхүүжилт 4,207.1 сая төгрөгөөс 182.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,907.6 сая төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 101.4 сая төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 132.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 16.1 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Хөрөнгө оруулалтын 21 төсөл, арга хэмжээнд 1035.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1035.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 16.1 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 64.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2368.5 сая төгрөг, нийт 2432.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 15.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 1.7 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 17.7 сая төгрөг, нормативт зардалд 0.09 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 21.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зарлалд 63.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 58.1 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 5.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 2192.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 57.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

ОНХСан болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын төлөвлөгөөнд тодотгол хийсэн тогтоолын хавсралт тооцооллын алдаатай, тогтоолын хавсралт хавсаргаагүй зэрэг баримтын бүрдэл дутуу байна.

#### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 131 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

#### **2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмж . Бүрэн хэрэгжсэн 3 хэрэгжээгүй 2 байна. Хэрэгжээгүй шалтгааныг САА-ны дарга Ш.Сувд-Эрдэнэ тайлбар гарган өгснийг ажлын баримтад хавсаргав.

#### **2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Замын сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байгууллага, сангуудын залруулагдаагүй зөрчлийн дүнг нэгтгэн үзэхэд 115.7 сая байх тул нийт зөрчлийг 115.7 сая төгрөгөөр тооцож бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс бага байх тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

##### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

##### 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,472,646.07</b>	<b>2,978,363.28</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>104,582.13</b>	<b>246,710.12</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>104,582.13</b>	<b>246,710.12</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>104,582.13</b>	<b>246,710.12</b>
31211	Төрийн сангийн харилцах	101,531.57	245,167.19
31213	Арилжааны банк дахь харилцах	3,050.56	1,542.93
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,077,430.44</b>	<b>918,171.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,318.35	4,444.86
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	249.57	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	246.90	0.00
33400	Зээлийн хүүгийн авлага	12,179.13	45,024.34
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>107,002.29</b>	<b>15,333.87</b>
33510	Байгууллагаас авах авлага	105,967.57	13,715.51
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,034.72	1,618.36
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>928,434.22</b>	<b>853,367.94</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>928,434.22</b>	<b>853,367.94</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	928,434.22	853,367.94
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>723,571.69</b>	<b>1,246,420.35</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>107,790.37</b>	<b>128,994.41</b>
35110	Тусгай зориулалттай материал	106,878.55	113,026.32
35130	Эм боох материал	911.82	15,968.09
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	41,955.05
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>614,656.32</b>	<b>1,074,345.89</b>
35410	Бичиг хэргийн материал	31,839.16	47,338.71
35420	Аж ахуйн материал	492,731.14	500,878.69
35430	Сэлбэг хэрэгсэл	288.00	456.20
35440	Түлш, шатах тослох материал	3,034.86	1,586.00
35450	Барилгын засварын материал	2,380.90	2,895.15
35460	Хүнсний материал	32,443.79	47,400.55
35470	Бусад хангамжийн материал	51,938.47	473,790.59
35600	Мал амьтад	1,125.00	1,125.00
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>567,061.80</b>	<b>567,061.80</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	567,061.80	567,061.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,614,092.22</b>	<b>22,397,076.71</b>

<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>18,614,092.22</b>	<b>22,397,076.71</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>17,680,568.43</b>	<b>21,410,181.26</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,061,340.51	20,777,822.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,851,909.38	-2,063,802.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	305,574.80	346,994.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-145,891.57	-167,888.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,409,899.32	1,508,124.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-770,378.79	-781,430.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	897,788.52	1,090,995.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	-353,215.11	-370,616.49
39209	Зам, гүүрийн байгууламж	889,566.57	889,566.57
39210	Хуримтлагдсан элэгдэл	-88,508.45	-157,424.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	446,326.83	432,673.39
39215	Хуримтлагдсан элэгдэл	-146,827.09	-161,543.98
39216	Дуусаагүй барилга, байгууламж	316.67	3,056.13
39217	Ном	26,485.61	63,654.69
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>933,523.79</b>	<b>986,895.46</b>
39301	Програм хангамж	9,106.30	11,341.30
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,602.51	-8,256.84
39303	Бусад биет бус хөрөнгө	931,031.00	983,811.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-11.00	0.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>21,086,738.29</b>	<b>25,375,439.99</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,748.31</b>	<b>2,877.04</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,748.31</b>	<b>2,877.04</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>2,748.31</b>	<b>2,877.04</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	272.94	1,200.14
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	85.18	0.32
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>2,390.19</b>	<b>1,676.58</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,753.89	1,184.79
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	636.30	491.79
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>21,083,989.98</b>	<b>25,372,562.95</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>21,083,989.98</b>	<b>25,372,562.95</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,617,977.58	6,807,536.58
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,136,559.00	0.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>9,633,262.77</b>	<b>13,868,938.70</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	9,764,333.64	9,668,158.05
51220	Тайлант үеийн үр дүн	-131,070.86	4,200,780.65
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,696,190.62	4,696,087.66
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН V</b>	<b>21,086,738.29</b>	<b>25,375,439.99</b>

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,951,483.50</b>	<b>22,526,921.49</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>4,378,335.72</b>	<b>4,536,440.87</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>2,470,612.92</b>	<b>2,288,254.07</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>2,470,612.92</b>	<b>2,288,254.07</b>
110002	Үйл ажиллагааны орлого	1,981,832.44	1,871,795.95
110008	Шууд бус орлого	488,780.49	416,458.11
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>2,672.00</b>	<b>2,824.00</b>
113002	Бууны албан татвар	2,672.00	2,824.00
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>1,905,050.80</b>	<b>2,245,362.81</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>1,905,050.80</b>	<b>2,245,362.81</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,853,914.44	2,174,230.57
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5,469.95	9,003.85
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	45,666.40	62,128.39
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,777,727.37</b>	<b>7,235,159.64</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,777,727.37</b>	<b>7,235,159.64</b>
120002	Хүүгийн орлого	12,179.13	4,785.00
120003	Торгуулийн орлого	1,114,109.55	2,014,316.36
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,953,546.64</b>	<b>4,664,549.49</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,503.62	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	912,221.53	7,050.29
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,039,821.49	4,657,499.20
120009	Бусад орлого	697,892.05	551,508.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,795,420.41</b>	<b>10,755,320.98</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>6,687,693.72</b>	<b>6,849,575.30</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	6,400,128.30	6,382,707.10
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	287,565.42	466,868.20
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0	0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,189.42</b>	<b>2,423,435.01</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,396.86	64,131.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,792.55	2,359,303.93

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>55,434.66</b>	<b>1,452,665.10</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	1,452,665.10
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	55,434.66	0
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>102.62</b>	<b>29,645.57</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	102.62	0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0	29,645.57
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,287,792.79</b>	<b>18,300,758.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,287,792.79</b>	<b>15,029,965.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,896,269.71</b>	<b>9,756,330.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>4,320,775.01</b>	<b>5,533,870.05</b>
210101	Үндсэн цалин	3,152,525.38	3,991,622.74
210102	Нэмэгдэл	580,714.65	839,933.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	25,396.00
210104	Урамшуулал	270,532.77	362,031.96
210105	Гэрээт ажлын хөлс	317,002.21	314,886.13
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>521,242.57</b>	<b>699,524.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	348,114.53	489,521.46
210202	Тэтгэмжийн даатгал	41,370.40	44,030.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	38,190.43	49,594.80
210204	Ажилгүйдлийн даатгал	9,061.05	9,144.58
210205	Эрүүл мэндийн даатгал	84,506.17	107,233.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,209,440.64</b>	<b>1,380,866.41</b>
210301	Гэрэл, цахилгаан	92,756.98	102,331.26
210302	Түлш, халаалт	1,007,413.86	1,185,968.85
210303	Цэвэр, бохир ус	109,269.81	92,566.29
210304	Байрны түрээс	0	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,456,499.97</b>	<b>796,682.15</b>
210401	Бичиг хэрэг	35,635.39	40,221.76
210402	Тээвэр, шатахуун	116,809.85	165,303.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,312.34	11,752.32
210404	Ном, хэвлэл	2,806.65	1,025.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,307.30	5,839.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,597.24	40,558.16
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал /ТӨҮГ/	4,594.56	18,961.59
210408	Бараа материал акталсны зардал	81,911.23	55,312.32
